

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТ

ХИЙСЭН ДҮНГИЙН ТУХАЙ

НЭГ. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ЗОРИЛГО

Булган аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албаны 2019 оны хяналт шалгалтын нэгдсэн төлөвлөгөө, Санхүүгийн хяналт, аудитын албаны даргын баталсан 2019 оны 07 сарын 31-ны өдрийн 1/15 дугаар удирдамжийн дагуу Булган сумын Спортын дунд сургуулийн 2017, 2018 оны санхүү аж ахуйн үйл ажиллагаанд Монгол Улсын Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулиуд болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад эрх зүйн актуудын хэрэгжилтийг шалгаж, зөрчил дутагдал илэрсэн тохиолдолд холбогдох хуулийн дагуу шийдвэрлэх, аливаа эрсдлээс урьдчилан сэргийлэх, цаашид давтан гаргахгүй байх талаар мэргэжил арга зүйн заавар, зөвлөгөө өгөхөд чиглэгдлээ.

ХОЁР. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН БҮРЭЛДЭХҮҮН, ХУГАЦАА

Санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч Б.Баттулга, Аудитор П.Пүрэвжав нар 2019 оны 07 сарын 31-ны өдрөөс 08 сарын 16 хүртэл хугацаанд шалгалтыг хийв.

ГУРАВ. ШАЛГАЛТАНД ХАМРАГДСАН АСУУДЛУУД

Сургуулийн 2017, 2018 оны касс, харилцах дансны гүйлгээг санхүүгийн анхан шатны баримттай тулган шалгасны зэрэгцээ цалин хөлс, урамшуулал, албан томилолтын бодолт, олголт, шатахууны олголт түүний зарцуулалтыг автомашины замын хуудастай тулгаж, бараа материалын худалдан авалт, зарцуулалт, эд хөрөнгийн тооллого тооцоо бодолт, санхүү, төсвийн ил тод байдлын хэрэгжилт, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт зэрэг хяналт шалгалтын удирдамжид заагдсан асуудлуудыг бүрэн хамруулан нягтлан бодогч Ж.Отгонтуяа, нярав М.Үүрийнтуяа нарыг байлцуулан төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийв.

ДӨРӨВ. ШАЛГАЛТАНД ХАМРАГДСАН ОБЪЕКТЫН ТАЛААРХ

ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

Булган сумын 5-р багт байрлах Спортын төрөлжөн сургалттай ерөнхий боловсролын сургууль нь 2017-2018 оны хичээлийн жилд хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх, сургалтын цөм хөтөлбөрийг боловсруулж спортын олон төрөлт тэмцээн, уралдаан зохион байгуулан ажилласан байна. Мөн хүүхэд элсүүлэх зорилгоор сумдын сургуулиудтай хамтран ажилласаар байна.

Сургуулийн захирлын 2017 оны 01 дүгээр сарын 02-ний өдрийн Б/01 тоот тушаалаар сургуулийн захирал 1, сургалтын менежер 1, СНА-н дотуур байрны багш 1, нярав 1, тогооч 1, жижүүр 6, үйлчлэгч 1, ерөнхий эрдмийн багш 4, спортын багш 3, гал тогооны ажилтан 1, Нябо 0,5, зөвлөх цагийн багш 1 нийт 21.5 хүний орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулж ирсэн байна.

Сургуулийн захирлын 2018 оны 01 дүгээр сарын 08-ний өдрийн Б/05 тоот тушаалаар Сургалтын менежер 1, нийгмийн ажилтан 1, дотуур байрны багш 1, түүх нийгмийн багш 1, хими, физикийн, багш 1, математикийн багш 1, монгол хэл уран зохиолын багш 1, хими биологийн багш 1, биеийн тамирын багш 4, гадаад хэлний багш 1, сургуулийн жижүүр 3, дотуур байрны жижүүр 3, сургуулийн үйлчлэгч 1, тогооч 1, нярав 1, дотуур байрны багш 1 нийт 23 хүний орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулж ирсэн байна.

Тус сургуулийн санхүүгийн үйл ажиллагааны 1-р гарын үсгийг 2017-2019 оны хагас жил хүртэл Ц.Цолмонбаатар 2019 оны 06 сарын 21 өдрөөс Б.Наранбат 2017-2018 онд Д.Ганцэцэг 2018 оны 3-р сараас Ж.Оюунтуяа нар 2-р гарын үсгийг зурж орлого зарлагын гүйлгээг хийж байна. Нягтлан бодох бүртгэл болон нярвын тайланг санхүүгийн тооцоолох “CTS” программаар бүртгэж хөтөлсөн байна.

ТАВ. ӨМНӨХ ШАЛГАЛТЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

Булган аймгийн Татварын хэлтсээс 2014-2018 оны санхүүгийн баримтанд хяналт шалгалт хийсэн байна. Уг шалгалтаар:

1. 2016 онд иргэдэд олгосон орлогоос хувь хүний орлогын албан татвар суутган авч төсөвт төлөөгүй 543.5 мянган төгрөгийн зөрчилд 54.3 мянган төгрөгийн нөхөн татвар, 16.3 мянган төгрөгийн торгууль, 11.1 мянган төгрөгийн алданги ногдуулах

2. 2017 онд иргэдэд олгосон орлогоос хувь хүний орлогын албан татвар суутган авч төсөвт төлөөгүй 556.2 мянган төгрөгийн зөрчилд 55.6 мянган төгрөгийн нөхөн татвар, 16.6 мянган төгрөгийн торгууль, 11.1 мянган төгрөгийн алданги ногдуулсан байна.

Булган сумын Спортын дунд сургуулийн 2018 оны 12 сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааварын дагуу үнэ бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй гэсэн санал дүгнэлт гаргасан байна.

ЗУРГАА. ШАЛГАЛТЫН ЯВЦАД ХИЙГДСЭН АЖИЛ, ШАЛГАЛТАД

ХАМРАГДСАН АСУУДЛУУД

6.1. Санхүүгийн эх үүсвэрийн бүрдүүлэлт, зарцуулалтын талаар: 2017 онд улсын төсвөөс 286001.6 мянган төгрөгийн санхүүжилт авахаар төлөвлөж, гүйцэтгэлээр 286001.6 мянган төгрөгийг авч, нэмэлт санхүүжилтээр 324.0 мянган төгрөг, нийгмийн даатгалын сангаас санхүүжих 1089.2 мянган төгрөг, засаг даргын нөөц хөрөнгөөс 1440.0 мянган төгрөгийн санхүүгийн эх үүсвэр бүрдүүлэн ажилласан байна.

2017 онд ажиллагсадтай холбоотой зардалд 174333.9 мянган төгрөг, тогтмол зардалд 68013.4 мянган төгрөг, үйл ажиллагааны үндсэн үзүүлэлттэй шууд холбоотой зардалд 15507.2 мянган төгрөг, бусад бараа үйлчилгээний зардалд 15380.4 мянган төгрөг, хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардалд 5439.7 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардалд 211.7 мянган төгрөг, биет бус хөрөнгө худалдан авах зардалд 375.4 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

2018 онд улсын төсвөөс 301093.9 мянган төгрөгийн санхүүжилт авхаар төлөвлөж, гүйцэтгэлээр 301093.9 мянган төгрөгийн санхүүжилт авч, нэмэлт санхүүжилтээр 1582.3 мянган төгрөгийн санхүүгийн эх үүсвэр бүрдүүлэн ажилласан байна.

2018 онд цалин хөлс нэмэгдэл урамшууллын зардалд 174258.6 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалын шимтгэлд 21696.9 мянган төгрөг, тогтмол зардалд 69234.9 мянган төгрөг, хангамж бараа материалын зардалд 1109.1 мянган төгрөг, бага үнэтэй түргэн элэгдэх ахуйн эд зүйл 123.1 мянган төгрөг, норматив зардалд 15843.4 мянган төгрөг, урсгал засварын зардалд 2867.4 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 42345.8 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Цалин урамшууллын талаар: Сургуулийн захирлын тушаалаар “Боловсролын тухай хуулийн” 43.1.7 дахь заалтыг үндэслэн Ц.Баттулгад 3467.0 мянган төгрөг, захирлын 2017 оны 03 сарын 24-ний өдрийн 07 тоот тушаалаар нэгдүгээр улирлын үр дүнгийн урамшууллыг 15%-45%-иар бодож нийт 1935.9 мянган төгрөг, захирлын 2017 оны 06 сарын 24-ний өдрийн А/18 тоот тушаалаар хоёрдугаар улирлын үр дүнгийн урамшууллыг 20%-45%-иар бодож нийт 1815.5 мянган төгрөг, аймгийн Засаг даргын 2017 оны А/391 тоот захирамжаар сургуулийн захиралд хоёрдугаар улирлын үр дүнгийн урамшуулал 45%-иар буюу 326.7 мянган төгрөг, аймгийн Засаг даргын 2017 оны 10 сарын 11-ний өдрийн А/512 тоот захирамжаар гуравдугаар улирлын үр дүнгийн урамшуулал 282.7 мянган төгрөг, аймгийн Засаг даргын 2017 оны 10 сарын 11-ний өдрийн А/514 тоот захирамжаар ур чадварын нэмэгдлийг 15%-иар буюу 145.0 мянган төгрөг, тус тус бодож олгосон байна.

Сургуулийн захирлын 2018 оны 01 сарын 25-ны өдрийн А/05 тоот тушаалаар “Боловсролын тухай хуулийн” 43.1.7 дахь заалтыг үндэслэн Н.Номин-Эрдэнэд 3247.0 мянган төгрөгийн тэтгэмж, сургуулийн захирлын 2018 оны 03 сарын 23-ний өдрийн А/07 тоот тушаалаар нэгдүгээр улирлын үр дүнгийн урамшуулал 30%-45%-иар буюу 4089.0 мянган төгрөг, 2018 оны 06 сарын 14-ний өдрийн А/12 тоот тушаалаар хоёрдугаар улирлын үр дүнгийн урамшуулал 35%-50%-иар буюу 4443.8 мянган төгрөг, 2018 оны 09 сарын 25-ны өдрийн А/16 тоот тушаалаар гуравдугаар улирлын үр дүнгийн урамшуулал 17%-30%-иар буюу 2647.9 мянган төгрөг, дөрөвдүгээр улирлын үр дүнгийн урамшуулалд 991.3 мянган төгрөг тус тус бодож олгосон байна.

6.2. Үндсэн хөрөнгийн хөдлөл өөрчлөлт:

№	Нэр	Мөнгөн дүн /төгрөгөөр/			
		Эхний үлдэгдэл	Орлого	Зарлага	Эцсийн үлдэгдэл
1	Барилга байгууламж	1448042760			1448042760
2	Машин тоног төхөөрөмж	94609913.58			94609913.58
3	Тавилга, эд хогшил	26625682			26625682
4	Биет бус хөрөнгө	1240000	250000		1490000
5	Бусад үндсэн хөрөнгө	2719255.60			2719255.60
6	Номын фонд	3605765	125400		3731165
	Дүн	1576843376.1 8	375400		1577218776.1 8

2017 оны эхэнд 1576843.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө дээр төсвийн хөрөнгөөр 250.0 мянган төгрөгийн программ хангамж, 125.4 мянган төгрөгийн ном авж оны эцэст 1577218.7 мянган төгрөгийн хөрөнгө бүртгүүлсэн байна.

6.3. Бараа материалын хөдлөл өөрчлөлт:

№	Тайлангийн нэр	Мөнгөн дүн /төгрөгөөр/			
		Эхний үлдэгдэл	Орлого	Зарлага	Эцсийн үлдэгдэл
1	Тусгай зориулалтын материал	11631077.82	3134300		14765377.82
2	Аж ахуйн материал	10075411.20	1098930	1266730	9907611
3	Түлш шатах тослох		1259080	1259080	
4	Хүнсний материал	3838825	17487590	18715265	2611150
5	Эм, боох материал		44300	44300	
6	Засварын материал	1009940	6594700	6392300	1212340.50
7	Бичиг хэрэг	148000	617650	590150	175500
	НИЙТ ДҮН	26703254.02	30236550.50	28267825	28671979.52

2017 оны эхэнд 26703.2 мянган төгрөгийн бараа материал дээр төсвийн хөрөнгөөр 26168.9 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан, хандиваар 750.0 төгрөгийн бараа материал, бусад 3317.6 мянган төгрөгийн бараа материал, 28267.8 мянган төгрөгийн бараа материалыг зарлагдаж оны эцэст 28671.9 мянган төгрөгийн бараа бараа материалын үлдэгдэлтэй гарсан байна.

6.4. Өглөг, авлагын талаар: Өглөг авлага гараагүй байна.

6.5 Шилэн дансны талаар: Шилэн дансны тухай хуулийн дагуу шилэн дансны нэгдсэн системд 2017 төсөв гүйцэтгэлийн 49 мэдээлэл оруулахаас 47 мэдээлэл хугацаанд нь оруулсан 2 мэдээлэл хугацаа хоцроож оруулсан Хөрөнгө оруулалт, тендер худалдан авалтын 39 мэдээлэл оруулахаас 39 мэдээлэл хугацаанд нь оруулж бусад мэдээлэл 61 мэдээлэл оруулахаас 60 мэдээлэл хугацаанд нь оруулж 1 мэдээлэл хоцроож оруулсан байна. Нийт 149 мэдээлэл оруулсан байна.

6.2. Үндсэн хөрөнгийн хөдлөл өөрчлөлт: 2018 он

№	Нэр	Мөнгөн дүн /төгрөгөөр/
---	-----	------------------------

		Эхний үлдэгдэл	Орлого	Зарлага	Эцсийн үлдэгдэл
1	Барилга байгууламж	1448042760	201810173.87		1036876227.90
2	Машин тоног төхөөрөмж	94609913.58			94609913,58
3	Тавилга, эд хогшил	26625682			26625682
4	Бусад үндсэн хөрөнгө	2719255.60	61532474.91	2285439.78	61966290.73
5	Биет бус хөрөнгө		35400000		35400000
6	Програм хангамж	1490000	200000		1690000
7	Номын фонд	3731165			3731165
	Дүн	1577218776.18	298942648.78	615262145.75	1260899279.21

2017 оны эхэнд 1577218.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө дээр барилга байгууламжийн дахин үнэлгээгээр 201810.1 мянган төгрөг, бусад үндсэн хөрөнгө 61532.4 мянган төгрөг, биет бус хөрөнгө 35400.0 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдэж 615262.1 мянган төгрөгийн хөрөнгө зарлагдаж оны эцэст 1260899.2 мянган төгрөгийн хөрөнгө бүртгүүлсэн байна.

6.3. Бараа материалын хөдлөл өөрчлөлт:2018 он

№	Тайлангийн нэр	Мөнгөн дүн /төгрөгөөр/			
		Эхний үлдэгдэл	Орлого	Зарлага	Эцсийн үлдэгдэл
1	Бичиг хэрэг	175500	622520	530620	267400
2	Аж ахуйн материал		2372000	1270400	1101600
3	Түлш шатах тослох		756170	756170	
4	Хүнсний материал	2611150	15657360	15322500	2946010
5	Засварын материал	1212340.50	5348330	3510130	3050540.50
6	Эм, боох материал		21500	21500	
7	Бусад хангамжийн материал	9907611.20			9907611.20
8	Тусгай зориулалтын материал	14765377.82			14765377.82
	НИЙТ ДҮН	28671979.52	24777880	21411320	32038539.52

2018 оны эхэнд 28671,9 мянган төгрөгийн бараа материал дээр төсвийн хөрөнгөөр 24777.8 мянган төгрөгийн бараа материал худалдан авч 21411.3 мянган төгрөгийн зарлага гарч оны эцэст 32038.5 мянган төгрөгийн бараа материал бүртгэгдсэн байна.

6.4. Өглөг, авлагын талаар: 2018 онд ажилчидтай холбогдсон өглөг 187.2 мянган төгрөг, бусад өглөг 17.2 мянган төгрөг нийт 204.4 мянган төгрөгийн өглөг, ажилчидтай холбоотой 30.9 мянган төгрөгийн авлагатай гарсан байна.

6.5 Шилэн дансны талаар: Шилэн дансны тухай хуулийн дагуу шилэн дансны нэгдсэн системд 2018 төсөв гүйцэтгэлийн 49 мэдээлэл оруулахаас 46 мэдээлэл хугацаанд нь оруулж 3 мэдээлэл хоцроож мэдээлсэн байна. Хөрөнгө оруулалт, тендер

худалдан авалтын 39 мэдээлэл оруулахаас 39 мэдээлэл хугацаанд нь мэдээлсэн. Бусад мэдээлэл 61 мэдээлэл оруулахаас 61 мэдээллийг хугацаанд нь оруулж нийт 149 мэдээлэл оруулсан байна

ДОЛОО. ШАЛГАЛТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ, ТҮҮНИЙ ШАЛТГААН,

ЗӨРЧИГДСӨН ХУУЛЬ, ТОГТООМЖ

1. 2017 оны 12 сарын 19-ны өдрийн 280 дугаартай төлбөрийн хүсэлтээр “Эрдэнэбармат” ХХК-д эмульсний үнэ 629125 төгрөг шилжүүлсэн нярав тайландаа орлого, зарлагаар тусгасан боловч анхан шатны баримт үйлдээгүй байгаа нь: Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль энэ хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.5, 13.7-дахь заалтуудыг тус тус зөрчсөн.

2. 2017 оны 6 сарын 15-ны өдрийн 123 дугаартай төлбөрийн хүсэлтээр “Булган-Аураг” ХХК-д материалын үнэ 348.0 мянган төгрөг шилжүүлсэн нярав 380.0 мянган төгрөгийг материалыг тайландаа орлого, зарлагаар тусгасан боловч 300.0 мянган төгрөгийн эмульсийг анхан шатны баримтгүй зарцуулсан нь: Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль энэ хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.5, 13.7-дахь заалтуудыг тус тус зөрчсөн.

3. 2017 оны 11 сарын 15-ны өдрийн 15 дугаартай төлбөрийн хүсэлтээр “Очирхүү” ХХК-д шилжүүлсэн хүнсний материалын үнэ 256.0 мянган төгрөгийн хүнсний материал нярав тайландаа орлого, зардлаар тусгасан боловч 256.0 мянган төгрөгийн хүнсний материалыг анхан шатны баримт үйлдээгүй нь: Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль энэ хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.5, 13.7-дахь заалтуудыг тус тус зөрчсөн.

4. 2017 оны 11 сарын 15-ны өдрийн 10 дугаартай төлбөрийн хүсэлтээр “Очирхүү” ХХК-д шилжүүлсэн хүнсний материалын үнэ 212.8 мянган төгрөгийн хүнсний материал нярав тайландаа орлого, зардлаар тусгасан боловч 212.8 мянган төгрөгийн хүнсний материалыг анхан шатны баримтгүй байгаа нь: Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль энэ хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.5, 13.7-дахь заалтуудыг тус тус зөрчсөн.

ЕС. АВСАН АРГА ХЭМЖЭЭ, МЭРГЭЖЛИЙН ТУСЛАЛЦАА, ЗӨВЛӨГӨӨ ӨГСӨН БАЙДАЛ

Шалгалтын хугацаанд 2 албан тушаалтанд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөв.

АРАВ. ДҮГНЭЛТ

Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1, 13.5, 13.7 дахь /шинэчилсэн/ заалтууд, няравын тайлан гаргалт анхан шатны баримтын бүрдэлт хангалтгүй, дотоод хяналт хэрэгжүүлээгүй байна.

АРВАН НЭГЭН. ЦААШИД АНХААРАХ АСУУДАЛ

Тушаал шийдвэрийн үндэслэлийг хууль эрх зүйн дагуу үг үсгийн алдаагүй гаргах.

Монгол улсын нягтлан бодох бүртгэлийн тухай, Төсвийн тухай хуулийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллах

Санхүүгийн үйл ажиллагаандаа дотоодын хяналт шалгалтыг тогтмол хийж санхүүгийн сахилга хариуцлагыг дээшлүүлэх

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.5, 13.7-дахь заалтууд, Шилэн дансны тухай хууль, журам, захирамж, шийдвэрүүдийг хэрэгжүүлж биелэлтийг тооцож, хариуг улирал тутам бичгээр Санхүүгийн хяналт аудитын албанд ирүүлэх

Илэрсэн зөрчлүүдийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх талаар анхааран тодорхой ажил зохион байгуулж ажиллах

БИЧСЭН: АУДИТОР

П.ПҮРЭВЖАВ